



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/77

Өмнөдэлгэр сум

**Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/150 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээний бүх үхэр, гахайг зааврын дагуу дархлаажуулах ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.
2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.
3. Дархлаажуулалтын ажилд онцгой ач холбогдол өгч, малчдад зар хүргэх, тарилгын хашаа хоолойг бэлтгүүлж, тарилгын ажилд хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, тарилгын дүн болон санхүүгийн баримт материалыг бүрдүүлэн аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасагт үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР



сумын Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 27-ны өдрийн
А/177 дугаар захирамжийн хавсралт

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ 2026 ОНЫ ХАВРЫН ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ МАЛЫН
ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Аж ахуйн нэгжийн нэр	Хамруулах мал, амьтан /толгой/			Шаардлагатай вакцин		Хайрцаг	Шил
		Үхэр	Гахай	Нийт	Тун	Литр		
1	Юмт гэгээ	23332		23332	23350	46.7	5	67
2	Хичээнгүй экспресс	5369		5369	5400	10.8	1	28
3	Мэргэн жонон	9578	126	9704	9700	19.4	2	34
4	Өвөр Зотлог	2912		2912	2900	5.8		58
5	Хэйлти анимал стронг	7720		7720	7700	15.4	1	74
	Дүн	48911	126	49037	49050	98.1	9	261